МЭДЭЭ · 2020 оны 6-р сарын 17

УЛСЫН ХИЛЭЭР АЛТ, ЗЭСИЙГ ХУУЛЬ БУСААР НЭВТРҮҮЛЭХИЙГ ЗАВДСАН ХЭРГҮҮДИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЖЭЭ



Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газраас Монгол Улсын хилээр хууль бусаар алт, зэс нэвтрүүлсэн хэргүүдийг шүүхээр шийдвэрлүүлж, хураагдсан зүйлсийн үнийг улсын орлогод төвлөрүүлжээ. Тухайлбал, иргэн Г нь 2019 оны 10 дугаар сард Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Авто замын шалган нэвтрүүлэх боомтоор нэвтрэхдээ биедээ 2,7 кг, иргэн П нь 2020 оны 4 дүгээр сард 1,3 кг алтан гулдмайг тус тус хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан хэргүүдэд Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэн тус сум дахь сум дундын шүүхэд шилжүүлсэн байна. Шүүхээс прокурорын яллах дүгнэлтийн дагуу дээрх эрүүгийн хэргүүдийг хянан хэлэлцээд, иргэн Г, П нарыг гэм буруутайд тооцон, торгох ял оногдуулж, хэрэгт хураагдсан алтыг улсын орлого болгон шийдвэрлэжээ.

Мөн 2019 оны 12 дугаар сард хилийн шалган нэвтрүүлэх боомтоор 2,6 кг зэсийг автомашиндаа нуун хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан иргэн Т-д холбогдох хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, шийдвэрлүүлсэн байна. Шүүхээс Т-г гэм буруутайд тооцон 500 мянган төгрөгөөр торгож, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан зэсийг, мөн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийг нь улсын орлого болгосон байна.

ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3165